

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнд “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаас мэдээлэв.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖ, ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭ

Гаалийн ерөнхий газрын нэгжүүдийн 2022 оны үйл ажиллагааг нийт 150 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 91.31 хувьтай байлаа.

Д/д	Эрэмбэ	Нэрс	Дүн
1	ГАЗАР	Төрийн захиргааны удирдлагын газар	95.56
2		Гаалийн хяналт, шалгалтын газар	94.00
3		Гаалийн зөрчилтэй тэмцэх газар	88.50
4		Татварын орлогын газар	93.60
5		Гаалийн бүрдүүлэлтийн газар	94.50
6		Гаалийн хорио цээрийн газар	81.00
7	ХЭЛТЭС	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	91.97
8		Хуулийн хэлтэс	90.30
9		Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	91.50
10		Гаалийн эрсдэлийн удирдлагын хэлтэс	91.80
11		Хүний нөөцийн хэлтэс	90.00
12		Статистикийн хэлтэс	93.50
13		Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	92.30
14		Боомтын хөгжлийн хэлтэс	91.00
15	ДЭРГЭДЭХ	Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар	88.25
16		Үйлчилгээ, аж ахуйн алба	93.00
17		Гаалийн төв лаборатори	92.50
18		Мэдээллийн технологийн төв	94.50
19		Эрэлч нохойн сургалтын төв	91.50
20		Хэвлэл мэдээлэл, сургалт, судалгааны төв	87.00
Дундаж үнэлгээ			91.31

ЗӨВЛӨМЖ

1. Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэн, батлуулах;

2. Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлт хангалтгүй арга хэмжээг байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулж хэрэгжүүлэх;
3. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагууд хоорондын үйл ажиллагааг уялдуулан, гүйцэтгэлийн чанарыг хангаж ажиллах;
4. Төсвийн тухай хуулийн 5.1.3-д заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчим, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.10.төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх заалтыг баримталж ажиллах;
5. Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа бүрэн хамруулах;
6. Боомтын дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулах хэрэгжилтэд хяналт тавих;

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

